



**БАГАХАНГАЙ ДУУРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 08 сарын 05 өдөр

Дугаар 8/177

Улаанбаатар хот

**44 дүгээр цэцэрлэгийн харьяа  
“Алтай” бүлгийн барилгын дотор засварын  
ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах  
Үнэлгээний хороо байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.44 дүгээр цэцэрлэгийн харьяа “Алтай” бүлгийн барилгын дотор засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны

дарга: Д.Хүрэлбаатар

Засаг даргын Тамгын газрын  
Тохижилт, худалдаа үйлчилгээний  
хэлтсийн дарга

Гишүүд: Θ.Амарзаяа

Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн хөгжлийн хэлтсийн  
Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, гэр  
бүл, хуүхэд, залуучуудын  
асуудал хариуцсан Ахлах  
мэргэжилтэн

Б.Хишиг-Ундрал

Багахангай тохижилт ОНӨААТҮГ-ЫН  
инженер

П.Бор

2 дугаар хорооны иргэн

Нарийн

бичиг: Д.Амгалан

Худалдан авах ажиллагааны албаны  
Ахлах мэргэжилтэн

2.Хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг Үнэлгээний хороо (Д.Хүрэлбаатар)-нд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

А.СҮХБОЛД